


25

Эрүүл мэндийн үйлчилгээ авах боломж



Зарим үйлдвэрт ажилчид эрүүл мэндийн зохистой үйлчилгээ авах боломжгүй байдаг. Олон үйлдвэрийн эзэд нь ажилчид эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжтой байснаар эрүүл саруул байж, ажилд ирэхгүй өдрүүд нь цөөрч, халаа сэлгээ багатай, бас үр дүнтэй ажилласнаар оруулсан хөрөнгө оруулалтгаа нөхөх болно гэж ойлгохын оронд энэ бүхнийг илүү зардал, нэрмээс гэж хардаг. Хэдий хуулиар үйлдвэрт болон орон нутагт эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжтой байх ёстай гэж тогтоосон байдаг ч ихэнхдээ тэнд үйлчилгээ авах боломжийг хуулиар мөрдүүлэх ямар ч арга байдаггүй.

Эрүүл мэндийн үйлчилгээны амлалтыг бодит ажил болгохын тулд ажилтан дараах зүйлсийг шаардах хэрэгтэй:

- Үйлдвэрт онцгой байдал эсвэл осол болоход эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжтой байх;
- Ажилчид эрүүл мэндийн үйлчилгээ авахад хялбар байлгах үүднээс

боломжтой цагаар нь эмнэлэг ажилладаг байхын сацуу бас тохиромжтой, чанартай тусlamж үйлчилгээ авах боломжийг бүрдүүлсэн байх;

- Ажилчдын гэр бүлийнхэн эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжтой байх;
- Улсын цагдаа нь эрүүл мэнд ба хүний эрхийн үйлчилгээ авах боломжийг дэмжин, олж хардаг байх;
- Эрүүл мэнд, аюулгүй байдлыг дэмжигчдийн сургалтын тусlamжтайгаар үйлдвэрийн ажилчдын эрүүл мэндийг хамгаалах, мониторинг хийх.

ҮЙЛДВЭР ДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Олон үйлдвэрийн эзэд нь ажлын байран дахь эрүүл мэндийн үйлчилгээг санал болгодоггүй. Харин тэд үүнийг санал болгох үед тэрхүү тусlamж үйлчилгээ нь хязгаарлагдмал, бас заримдаа тийм ч сайн биш байдаг. Үйлдвэрээс цалинждаг эмч, сувилагч нар нь менежментийн багийн нэг хэсэг байдаг тул ажиллагчдын эрүүл мэндийг сайжруулахаас илүүтэйгээр үйлдвэрлэлийн гэх дарамтад орсон байх магадлалтай байдаг. Гэвч үнэнч шударга эмч нар нь ажилчдын хувьд нэн чухал мэдээллийн эх сурвалж төдийгүй хэрэгтэй үед холбоотон нь болдог.

Шаардлага хангасан үйлчилгээгүй бол бага зэрэг өвдөлт, зовуурь болон гэмтлүүд нь яваандaa томоохон асуудал болон хувирдаг. Эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний тухай үйлдвэрийн дүрэм журам нь асуудлыг илүү муутгадаг. Эдгээр дүрмүүд нь ажилчид завсарлага авах эсвэл тэд цалинтайгаа залгах үедээ эмч рүү явах, мөн өвчин зовуурь гэмтлээ эдгээх хугацаа хэрэгтэй үед, аль эсвэл гэр бүлийнхнийхээ өвчинд санаа тавихад илүү хэцүү болгосон заалттай байдаг. Өндөр төлбөртэй эрүүл мэндийн үйлчилгээ ч нэгэн адил ажилчдад шаардлагатай эрүүл мэндийн үйлчилгээгээ авах боломжийг олгодоггүй.

ГЭМТСЭН АЖИЛЧДЫГ ДЭМЖИХ БА ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ

Үйлдвэр нь ажлын байранд гэмтсэн ажилчдын эмчилгээний зардлыг төлөх ёстай. Үүнд онцгой байдлын үеийн тээвэрлэлт, гэмтэлд үзүүлэх тусlamж, ноцтой гэмтэл, бас хэт их ажилласнаас үүсэх асуудал болон химиин бодис, халуун, хүйтэн, дуу чимээнээс үүссэн асуудлууд багтана.

ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОВСРОЛ

Зарим холбоод, ажил олгогч нар нь ажлын өдрөөр ДОХ, БЗХӨ, сүрьеэ, нөхөн үржихүйн эрүүл мэнд, хүнс тэжээл болон эрүүл мэндийн бусад асуудлын талаар ажилчдад боловсрол олгох үйл ажиллагааг зохион байгуулдаг. Энэ

нь ажиллагчдын өвчлөл, чөлөө авах болон халаа сэлгээг багасгаж, ажлын бүтээмжийг дээшлүүлдэг тул үйлдвэрийн эзэд дэмждэг.

Үйлдвэр дэх эрүүл мэндийн сурталчилгаа

Бизнес дэх нийгмийн үүрэг хариуцлагын HER төсөл нь ажилчид, ахлагч нарын мэдлэгийг “Үе тэнгийн эрүүл мэндийн багш нар” эрүүл мэндийг сургалтын хүрээнд сайжруулахаар хичээсээр байна. Тэд ажилчид, эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн талаар олон сэдвийг багтаасан ажилтныг сургах 12 сургалтын хөтөлбөр боловсруулсан. Ажилчид үүнийг бусад хамтран ажиллагчдаа тарааж байна.

Мексикийн Сиудад Хуарезд цусны даралт ихдэх өвчин болон чихрийн шижин түгээмэл байдаг ба 50 үе тэнгийн багш нар мэдлэгээ электроникийн үйлдвэрийн завсарлага, цайны цаг болон зорчигчдын автобусанд 1000 хамтран ажиллагчдаа түгээхээр сургалтад хамрагдсан байна. Үйлдвэрийн эмнэлэг нь эрүүл мэндийн боловсролыг дэмжих чиглэлээр чихрийн шижингийн үзлэг хийх, хөхний болон умайн хорт хавдрын үзлэг, цусны даралт ихдэх, мөн түүнчлэн вакцинжуулах, жирэмсний болон хүүхэд асрах зөвлөгөө өгөх, эрүүл мэндийн үзлэгт хамруулах үйлчилгээ хийж байна.

Анхны тусламж ба эрүүл мэндийн үйлчилгээ

Хэдийгээр үйлдвэрт эмнэлэг байхгүй байсан ч бүх ажлын байр нь анхны тусламжийн багц бүрдүүлж, онцгой байдлын үед хариу арга хэмжээ авах талаарх сургалтад ажилчдыг хамруулсан байх нь чухал юм. Нэг ажилтан гарлаа гэхэд түүнийг нөгөө нэг нь орлоход бэлэн байлгахаар сургалтыг тогтмол хийж байх хэрэгтэй.

Анхны тусламжийн багц нь үйлдвэр даяар аюулгүй, цэвэр хадгалагдах хэрэгтэй. Ажилчид хялбархан авч хэрэглэх боломжтой байх хэрэгтэй. Таны үзүүлэх анхны тусламжийн багцад байх зүйлс нь ямар төрлийн ажил хийдгээс хамаарах боловч багцад нь ерөнхий гэмтлүүд буюу түлэгдэх, зүсэгдэх, унах үед зэрэг нөхцөлд эмчлэх ерөнхий бүх материал орсон байх хэрэгтэй. Материал нь байлаа гээд ажилчид, ахлагчид нь тэдгээрийг ашиглан хэрхэн анхны тусламж үзүүлэх, тусламж авч чадах хүртэл гэмтсэн ажилтны биеийн байдлыг тогтвржуулах сургалтад хамруулаагүй бол энэ нь тийм ч үр дүнтэй биш байх болно. Анхны тусламжийн багц тус бүрт орон нутгийн түргэн тусламжийн байгууллагын буюу эмнэлгийн утасны дугаарыг бичсэн байх ёстой.

Дасгал**Үйлдвэрийн онцгой байдлын төлөвлөгөө**

Дараах үйл ажиллагааг ашиглан 64-65-р хуудаснаас жишээ авч ажилтанд тулгарч байгаа аюулыг илрүүлэн газрын зураг зур.

Дараа нь доорх асуултад хариулт олохын тулд хэлэлцүүлэг зохион байгуул:

- Ажилчид биеийнхээ аль хэсэгт ихэвчлэн гэмтэж байна вэ?
- Ямар тоног төхөөрөмж хамгийн аюултай вэ?
- Гэмтсэн ажилчид ямар төрлийн тусlamж үйлчилгээ авч байна вэ?
- Эдгээр асуудлыг арилгахын тулд үйлдвэрийн эзэд ямар арга хэмжээ авч байна вэ?

Эдгээр мэдээллийг, мөн одоо мэдэгдэж байгаа аюул буюу гал, цахилгааны доголдол, газар хөдлөлт гэх мэтийг ашиглан ажил олгогчтойгоо хамтран үйлдвэрийн онцгой байдлын төлөвлөгөө боловсруул.

Онцгой байдлын төлөвлөгөөнд зөвхөн анхны тусlamжийн багцаас гадна яаралтай эмчилгээ хийх буюу нүд угаалтуур болон шүршүүр ордог ч мөн дараах асуултад хариулах детальчилсан хариу арга хэмжээ орно:

- Онцгой байдлын үед хэн анхны тусlamж үзүүлэх үүрэгтэй вэ?
- Тэр юу хийх хэрэгтэй вэ? Жишээлбэл: тэд тоног төхөөрөмжийн тогийг салгах хэрэгтэй юу? Хэрвээ ажилтан цус алдаж байвал ямар арга хэмжээ авах хэрэгтэй вэ?
- Тэд хаанаас эрүүл мэндийн ажилтны нэмэлт тусlamж авч болох вэ?
- Хэзээ, бас яаж гэмтсэн ажилтныг түргэн тусlamж болон эмнэлэг рүү тээвэрлэх хэрэгтэй вэ?

ЭМНЭЛЭГ БОЛОН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН САЙН ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ

Ажилчид ихэвчлэн эрүүл мэндийн сайн үйлчилгээ авахад бэрхшээлтэй байдаг. Түргэн тусламж болон эмнэлгүүд нь үйлчилгээ болон эмчилгээндээ их мөнгө нэхэж, үйлчилгээ авахад хэцүү, хэт их хүнтэй эсвэл таныг очиж чадах үед хаалттай, аль эсвэл эмэгтэй болон шилжин ирсэн ажилчин учраас зэлдэг бус харьцаж болох юм.

Өвчилсөн байх үедээ ажиллах нь нэмэлт асуудал үүсгэдэг бөгөөд нэгэнт олон төрлийн эрүүл мэндийн асуудалтай бол бүх асуудлыг ажлаас шалтгаалж үүссэн гэдгийг нь олж харахад хэцүү болгодог. Жишээлбэл, ачааллтай ажиллах, нэг төрлийн хөдөлгөөнөө амралтгүй хэт их давтан хийснээс үүсэх гэмтэл, богино болон урт хугацаанд ажлын байранд химийн бодисын нөлөөнд орсон зэрэг ажлын нөхцөлийг багасгасан эсвэл зогсоосон, аль эсвэл сайжруулсан байдаг. Гэвч ихэнх ажил олгогчид ажилчдын нурууны өвчин, толгой өвдөх, арьсны тууралт, амьсгалын асуудал, хорт хавдар зэргийг ажлаас шалтгаалсан гэдгийг хүлээн зөвшөөрөхөөс татгалздаг. Ихэнх эмч нар болон сувилагч нар хөдөлмөрийн эрүүл мэнд эсвэл экспортын чиглэлийн үйлдвэрийн нөхцөл

Олон эмч нар зелдэг байдаг ч тэд бидний ажлын талаар үнэндээ юу ч мэддэггүй. Тэд бидний ажиллаж байгаа химийн бодисын аюулын талаар хаанаас олж харахаа ч мэддэггүй.

Тийм ээ. Бид химиийн бодисоо солих үед миний толгой өвдөж эхэлсэн гэвн эмч чамд ямар ч асуудал байхгүй байна гэж хэлсээр л байсан.



байдлын талаар мэдэж, суралцдаггүй тул ажилчид сайн тусlamж үйлчилгээ авч чаддаггүй.

Ихэнх тохиолдолд хөдөлмөрийн чадвар алдсан эсвэл гэмтсэн ажилчид ажлаасаа болон дарга нараасаа ямар ч дэмжлэг авдаггүй. Тэд хэрвээ өвчлөл нь ноцтой, бас тэдэнд эмчилгээ эсвэл тусгай багаж хэрэгсэл хэрэгтэй болох юм бол ажлаасаа халагдах болдог бөгөөд эмчилгээнийхээ зардлыг өөрсдөө төлөх хэрэгтэй болдог. Дийлэнх нь үүнийг төлөх чадваргүй байдаг.

Ажлаас шалтгаалсан өвчлөл, гэмтлийг хүлээн зөвшөөрөх

Зарим эмч нар ажилчдын эрүүл мэндийн асуудал хийж байгаа ажлаас нь хамааралгүй гэж хэлдэг. Тэд ажиллагчдын өмнөх нөхцөл байдал нь эрүүл мэндийн асуудлын шалтгаан болсон эсвэл түүний муу зуршиас болсон, аль эсвэл гэр булийнх нь амьдралаас, мөн түүний орон нутгийн эрүүл бус нөхцөл байдлаас шалтгаалсан гэж ажилчдыг буруутгадаг. Ажлаас үүссэн гэмтэл, өвчлөл нь ажлын муу нөхцөл, аюултай химиин бодис, бас тоног төхөөрөмжид өртөлт, сургалт дутмаг байдал болон онцгой байдлын үед тусlamж үйлчилгээ авах боломжгүйгээс гол төлөв шалтгаалдаг.



Ажлаас шалтгаалсан өвчлөл, гэмтлийг танай улсад хэрхэн тодорхойлдог болохыг олж мэд. Энэ нь магадгүй та болон тантай ижил бүлэг ажилчдын эрүүл мэндийн асуудлыг ажлаас шалтгаалсан гэдэгт ажил олгогч, засгийн газрын мэргэжилтүүдийг итгүүлж, тэд ажлаас шалтгаалсан гэмтэл болон өвчлөлийг тогтоож, эмчилгээний зардлыг төлүүлэх, бас ажилчдын нөхөн олговрын тогтолцоог бий болгож, шийдэх ёстой.

Бид үйлдвэрт нас барсан хамтран ажиллагчийнхаа тухай том плакат хийсэн. Бид тэр хэн байсан, яаж нас барсан, одоо тэдний гэр бүл нь хэрхэн шаналж байгаа талаар ярилцсан. Бид плакатаа хотод зохион байгуулсан арга хэмжээ, парад, байгууллагын зугаалга болон бүтэн сайн өдөр сүмд аваачсан.



Ажлаас шалтгаалсан осол гэмтлийн нөхөн төлбөр авах эрх



ОУХБ-ын Ажил эрхлэлтийн ослын тэтгэмжийн конвенц (№121)-ийн дагуу засгийн газар нь нөхөн сэргээх, хөдөлмөрөөс шалтгаалсан өвчлөлд дараарх зүйлсийг багтааж, өвдөж шаналж байгаа ажилчдыг хэрэгцээт зүйлсээр хангах хэрэгтэй гэж заасан байдаг:

- Тоосноос шалтгаалсан өвчлөл;
- Агаар дахь жижиг тоосонцорт өртсөнөөс болж үүссэн өвчлөл;
- Химиин бодист өртсөнөөс болж үүссэн өвчлөл;
- Дуу чимээ, чичиргээ болон бусад аюулаас шалтгаалан үүссэн эрүүл мэндийн асуудлууд.

ОУХБ-ын Мэргэжлээс шалтгаалсан өвчлөлийн зөвлөмж (№194)-ийг мөн үзнэ үү.

Ажил эрхлэлтийн ослын тэтгэмжийн конвенцод засгийн газар дараах байдлаар нөхөн төлбөрийг олгуулах хэрэгтэй гэсэн байдаг:

- Өвчлөл болон гэмтлээс болж дахин хөдөлмөрлөх чадваргүй болсон ажилчинд;
- Ажлаас болж эсвэл ажил дээрээ амь насаа алдсан ажилчны гэр бүлд.

Тэтгэмж нь эрүүл мэндийн төлбөр, ажилчдын нөхөн сэргээх эмчилгээг заавал хангах ёстой ч, мөн өвчлөл болон өвчинөөс нь хамаарсан бэлэн мөнгөний тэтгэмжийг багтаасан байх хэрэгтэй.

Ажилчдын эрхийг дэмжих олон улсын байгууллага НҮБ, ОУХБ-ын үүргийг
Хавсралт А-д тайлбарлав.

Үйлдвэрээс санхүүждэг ч ажил олгогчийн өмч биш

Бангладеш улсад ажилчид үнийг нь төлж чадахуйц эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжтой олон байгууллага байдаг. Гэвч үйлдвэрт ажилладаг олон хүмүүст эмчид үзүүлэх цаг байхгүйгээс эсвэл үйлдвэрээ орхиж гарах зөвшөөрөл байдаггүйгээс эрүүл мэндийн зохистой үйлчилгээ авч чаддаггүй. Тийм хүмүүст хүрч үйлчлэхийн тулд Мэри Стопсын олон улсын байгууллага “Үйлдвэрийн эрүүл мэндийн үйлчилгээ”-г бий

болгосон түүхтэй. Энэ эмнэлэг нь үйлдвэр дотор байдаг ба үйлдвэрийн эзэд санхүүжүүлдэг хэдий ч тэднээс хараат бус үлдэж чадсан юм. Ажилчид өөрсдийнхөө хэрэгцээнд тохируулан эмнэлгийн тусlamж үйлчилгээ авч чаддаг ч эмнэлэг нь үйлдвэрт ажилчдын эрүүл мэнд ямар байгаад тогтмол үзлэг шалгалт хийхийг санал болгодог юм. Эмнэлэг нь ажлын өдөр дууссанаас хойш удаан нээлттэй байж, үйлдвэрийн удирдлага нь ажилчдаа эмнэлгийн тусlamж үйлчилгээ үнэгүй авах төлбөрийг нь төлдөг. Одоо эндээс олон хүн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээ авах боломжтой болсон байна.

Бидэн шиг байгууллагаас санхүүжэдэг газарт үл итгэлийн асуудлыг шийдэхээр бид олон ажилтан болон байгууллагатай хамтран ажиллаж байна. Тэдэнд эми, сувилагч нар яак ажиллаж байгааг харуулсан. Хэдийгээр дарга нь ажиллагчдыг эмнэлэгт үзүүлэх төлбөрийг төлдөг ч эми, сувилагч нар нь хараат бус.



Тусгай хэрэгцээт ажилчид

Бүх ажилчид өөр өөрийн гэсэн онцлог ялгаатай бөгөөд тэд бидэнтэй хамт ажилладаг. Өөр өөр ялгаатай талууд нь ажлын байранд бидний ажлыг гол төлөв улам үр ашигтай болгодог. Бидний эрүүл мэндийн хэрэгцээ өөр өөр байх үед бусад бүх хүн өөрсдийн хэрэгцээт анхаарал халамжийг авах ёстой болдог. ДОХ-той ажилчид нь тэдэнд шаардлагатай эм, тэжээл, амралт, бас тэдэнд хэрэгтэй хүндэтлэй байснаар үр дүнтэй ажиллаж, урт удаан эрүүл амьдарч чадна: (30-р бүлгийг үзнэ үү). Эмчилгээний болон ажлын уян хатан нөхцөлтэй байснаар хөдөлмөрийн чадвараа алдсан ажилчид ч үр бүтээлтэй олон жил үргэлжлүүлэн ажиллаж чадна.


Эмэгтэй ажилчид ба тэдний эрүүл мэнд

Эмэгтэйчүүд улсын хүн амын тал нь байдаг ба ихэвчлэн эмэгтэйчүүд үйлдвэрт ажилладаг ч эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн хэрэгцээг хөдөлмөрийн эрүүл мэндэд ч, ерөнхий эрүүл мэндэд ч онцгойлон анхаарч авч үздэггүй. Олон төрлийн химийн бодис эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн тогтолцоонд нөлөөлдөг тул жирэмсэн ажилчид (төрөхийн өмнөх үйлчилгээ) үзлэг, хяналтад заавал орж, эх хүүхдийн эрүүл мэндийн асуудлыг илрүүлж, эмчилгээ хийх хэрэгтэй байдаг. Ажлын байранд хөдөлмөр хамгаалал сайн хийгдэж, аюулгүй болоогүй бол олон

оронд жирэмсэн эмэгтэйчүүдийг илүү аюул багатай ажилд шилжүүлэх эсвэл өөр ямар ч аюулгүй ажил олдохгүй бол буцалтгүй тусламж өгч явуулдаг.

Эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн буухиа тэрэг

Хятадын Ажилчин эмэгтэйчүүдийн сүлжээ (CWWN) нь үйлдвэрт ажилладаг эмэгтэйчүүдтэй эрүүл мэндийн асуудлаар уулзаж ярилцах шинэ арга бий болгожээ. Тэд эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн Буухиа тэрэг буюу Pearl River Delta үйлдвэрийн бүсийн үйлдвэрүүдийн гадна зогсох машин явуулж эхэлсэн байна. Машинд зочилсон эмэгтэйчүүд олон өвчний шинж тэмдгийг шалгуулж, эрүүл мэндийн болон эмчилгээний талаар, мөн түүнчлэн ажлын аюулаас шалгаалж буй эрүүл мэндийн асуудлын талаар мэдээлэл авдаг байв.



Эрүүл мэндийг сурталчлагч нар нь эмэгтэй ажилтнууд байдаг бөгөөд эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн буухиа тэрэг нь эмэгтэй ажилчдын хувьд өөрсдийн асуудлыг санаа зоволгүйгээр ярьж болдог газар болжээ.



Эрүүл мэндийн үйлчилгээ авах эрх



Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай НҮБ-ын конвенцод эрэгтэй ба эмэгтэй хүмүүс ижил тэгш эрүүл мэндийн үйлчилгээ, мэдээлэл, мөн гэр бүл төлөвлөлтийн мэдээлэл авах ёстой. Ажиллах хүчний ялгаварлан гадуурхлыг арилгах конвенцын талаар илүү их мэдээлэл авахыг хүсвэл Хуудас 404-405, Эрх тэгш байх эрх хэсгийг үз.

Хэд хэдэн ОУХБ-ын конвенц (№102, 121, 130, 183)-д засгийн газар нь эрүүл мэнд, эрүүл мэндийн үйлчилгээ, ажилчдын болон тэдний гэр булийн нийгмийн хамгааллын чиглэлээр дараах зүйлсийг хангах ёстой гэсэн байдаг:

- Ажилчид, түүний хамтран амьдрагч, тэдний хүүхдэд зориулсан эмнэлгийн үйлчилгээ;



Эрүүл мэндийн үйлчилгээ авах эрх (үргэлжлэл)



- Өвчтэй үеийн цалинтай чөлөө олгох;
- Ажлын байранд гэмтсэн бол эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх;
- Хөдөлмөрийн чадвар алдсан ажилчид өмнөх ажилдаа эргэн ороход эсвэл түүнд тохирохуйц ажилд орох чадвартай болоход нөхөн сэргээх үйлчилгээнд нь туслах;
- Ажлаас шалтгаалж өвчтэй болсон эсвэл гэмтсэн ажилчдад гэмтлийн нөхөн төлбөр төлөх;
- Гэмтэж, дахин ажиллаж чадахгүй болсон, аль эсвэл гэмтэхээсээ өмнө илүү бага цалин авдаг байсан ажилчдад хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмж төлөх;
- Амь үрэгдсэн ажилчдын ар гэрт нөхөн төлбөр төлөх;
- Ажлаас шалтгаалсан гэмтэл, өвчлөл буюу химиин бодис, тоос, дуу чимээ, чичиргээ болон бусад аюулаас шалтгаалсан өвчлөлийг тодорхойлох.

Ажилчдын эрхийг дэмжих олон улсын байгууллага НҮБ, ОУХБ-ын үүргийг Хавсралт А-д тайлбарлав.

Хэрхэн

Илүү сайн халамж хүртэх

Эмч нар өвчний шинж тэмдгийг таньж, асуудлыг тодорхойлж, тэдгээрийг эмчлэх талаар мэргэжлийн түвшинд бэлтгэгдсэн байdag. Гэвч олон эмч хэзээ ч үйлдвэр дотор орж ажиллаж үзээгүй байdag. Эмч нар магадгүй үйлдвэрийн ажил, бас ажилчдын эрүүл мэндэд нөлөөлж байгаа нөхцлийн талаар бага мэддэг байж болох юм. Хэрвээ боломжтой бол:

- Тэднийг өөрсдийн биеэр ирж үйлдвэрийн нөхцөл байдалтай танилцуулахаар зочлуулах ажлыг зохион байгуул;
- Эмч нарыг олон нийтийн үйл ажиллагаанд оролцуулж, хүмүүсийн гэрт зочлуул;
- Эмч нарыг ажилчдын уулзалт, үйлдвэрийн цех буюу ажилчид байdag газарт очих эсвэл үйлдвэрийн талаар мэдлэгтэй болоход нь туслах зорилгоор

ажиллагчдын түүхийг жүжигчлэн үзүүлэх үйл ажиллагаа зохион байгуул.

Эмнэлэг дээр

Эмч, сувилагч эсвэл эрүүл мэндийн ажилтан нь таны өнгөрсөн амьдралын тухай болон одоо ямар эрүүл мэндийн асуудал байгаа талаар асуух болно. Тааламжгүй байлаа ч хамаагүй эмч таны эрүүл мэндийн талаар аль болох их зүйлийг мэдэж авахаар бүрэн мэдээлэл өгөхийг хичээ. Эмчид өөрийн байнга хэрэглэж байгаа эм, эмчилгээ, аспирин гэх мэт эсвэл гэр бүл төлөвлөлтийн арга зэргийг хэлж бай. Учир нь зарим эмчилгээ нь бусад эмийн үйлчлэлд нөлөөлдөг.

Дараах асуултууд нь танд өөрийн асуудлаа тайлбарлахад бэлдэхэд тань туслах болно:

- Хэзээ анх энэ асуудлыг анзаарсан бэ?
- Ямар шинж тэмдэг илэрснээр та ямар нэг юм болоод байна гэж бодож эхэлсэн бэ?
- Танд эдгээр шинж тэмдэг хэр ойрхон илэрсэн бэ?
- Танд өмнө нь ийм шинж тэмдэг байсан уу, аль эсвэл танай гэр бүлийнхний хэн нэгэнд эсвэл орон нутгийн хэн нэгэнд байсан уу?
- Юу шинж тэмдгийг илүү муутгаж эсвэл сайжруулж байсан бэ?



Ихэнх эмч нар үйлдвэрийн ажлаас шалтгаалсан гэмтэл болон өвчлөлийг эмчилхээр бэлтгэгдээгүй байдаг. Эмчид яг юу хийдгээ маш тодорхой харуул.

Хэрвээ таны асуудал таны ажил дээр хэрэглэдэг химийн бодистой холбоотой гэж сэжиглэж байгаа бол чадах хэмжээгээрээ их мэдээлэл авчирч өг: химийн бодисын нэр эсвэл үйлдвэрлэгч, юунд хэрэглэгддэг, өнгө, үнэр эсвэл хэлбэр, бас юу гэдгийг нь эмч мэдэж авахад тус болох бүх зүйлийг хэлж өг. 216-225 дугаар хуудсыг үзнэ үү.

Таны эрүүл мэндийн асуудлыг шийдвэрлэхэд сайн шийдвэр гаргуулахын тулд аль болох олон асуулт асуух хэрэгтэй. Эмчийн тайлбарлаж байгаа нь танд хэр ойлгомжтой байгааг баталгаажуул:

- Энэ асуудлыг эмчлэх өөр ямар ямар аргууд байгаа вэ? Гэрээр өгөх эмчилгээ байгаа юу?

- Эмчилгээг яаж хийх вэ? Үүнд ямар нэгэн аюул байгаа юу?
- Хэзээ миний бие сайжрах вэ?
- Би эмчлэгдх үү? Эсвэл өвчин зовуурь дахих уу?
- Шинжилгээ болон эмчилгээний зардал хэд болох вэ?
- Гэрээр эмчилгээ байгаа юу?
- Яагаад энэ асуудал бий болсон бэ? Би үүнийг дахин тохиолдооос урьдчилан сэргийлж чадах уу?

Олон эмч, сувилагч нар өвчний дэлгэрэнгүй мэдээллийг өгдөггүй. Эсвэл тэд завгүй, бас танд цаг гаргаж асуултад чинь хариулахыг хүсэхгүй байж болох юм. Хүндэтгэлтэй ханд, гэхдээ өөрийн шийдвэрт баттай зогс. Таны эрүүл мэнд тэдний үзүүлж байгаа үйлчилгээнээс хамаардаг учир тэднээс аиж эмээх хэрэггүй бөгөөд танд үзүүлж байгаа үйлчилгээнд нь та сэтгэл хангалаун байх ёстой юм. Тэд таныг ойлгох хүртэл тайлбарлах ёстой. Хэрвээ та ойлгоогүй бол энэ нь та хангалттай ухаантай гэсэн үг биш ба тэд л хангалттай сайн тайлбарлахгүй байна гэсэн үг юм.

Эрүүл мэндийн үзлэг

Юу нь болохгүй байгаа, асуудал хэр ноцтой болохыг мэдэхийн тулд танд эмчийн үзлэг хэрэгтэй байж болно. Үзлэгт таны биеийн аль хэсэгт асуудал мэдрэгдэж, сонсодож, үзэгдэж байгаа зэрэг нь багтана. Ихэнх үзлэгт биеийнхээ аль асуудалтай байгаа хэсгийг ил гаргах хэрэгтэй болдог.

- Найзуудаасаа хэн нэгнийг эсвэл гэр бүлийн гишүүнээ үзлэг хийх үед таны хажууд өрөөнд байлгаснаар танд илүү тааламжтай байж болно.

Шинжилгээ авах


Шинжилгээ авах нь эрүүл мэндийн асуудлын талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл өгдөг. Шинжилгээнд гол төлөв бага хэмжээний шээс, өтгөн эсвэл цэр авч бас тэдгээрийг лаборатори руу илгээдэг. Эсвэл зүү ашиглан бага хэмжээний цус таны хуруу эсвэл гараас авдаг.

- Яаж, бас хэрхэн шинжилгээ авах талаар эмчээсээ асууж, тайлбарлаж өгөхийг хүс.
- Ямар нэгэн шинжилгээ өгөхөөсөө өмнө үнийн талаар асуу.
- Хэрвээ шинжилгээ хийгдэж дуусаагүй бол шинжилгээнээс эмч ямар зүйлсийг олж мэдэж болох талаар асуу.

Эрүүл мэндийн үйлчилгээг хүндлэлтэй үзүүлэх

Танд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж байгаа бүх хүн чадах чинээгээрээ ажиллаж, дараах үйлчилгээг үзүүлнэ:

- 1. Үйлчилгээ авах боломж:** Та хаана амьдардаг эсвэл хаанаас ирсэн, хэр үнэтэйг та авч чадах, шашин, хэл, нас, арьсны өнгө, улс төрийн үзэл баримтлал эсвэл танд эрүүл мэндийн ямар асуудал тулгарснаас үл хамааран та эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжтой байх ёстай;
- 2. Мэдээлэл:** Таны эрүүл мэндийн асуудал, бас боломжит эмчилгээг тайлбарлаж өгсөн байх хэрэгтэй. Эмч таны биеийн байдлыг илүү сайжруулахад юу хийх хэрэгтэйг болон хэрхэн энэ асуудлууд дахин тохиолдооос урьдчилан сэргийлэхийг ойлгуулахад туслах ёстай;
- 3. Сонголт:** Та эмчлэгдэх ч бай, үгүй ч бай яаж эмчлэх талаар сонгох боломжтой байх хэрэгтэй. Мөн түүнчлэн хэрвээ танд өөр сонголт байгаа бол хаана очиж эмчлүүлэхээ сонгох боломжтой байх ёстай;
- 4. Аюулгүй байдал:** Эмчилгээнээс үүсэх шинэ асуудлууд эсвэл ямар нэгэн гаж нөлөөллөөс сэргийлэх мэдээллийг танд өгсөн байх ёстай;
- 5. Хүндлэл:** Танд үргэлж хүндлэлтэй, эелдэг хандах ёстай;
- 6. Нууцлал:** Эмч, сувилагч эсвэл эрүүл мэндийн ажилтанд хэлж байгаа зүйлсийг бусдад эсвэл хэн нэгэнд хэлээгүй, бусдад санаандгүй сонсогдохооргүй байх ёстай. Үзлэг нь таны биеийн хэсгийг бусад хүн харахааргүй газар нууцлалтай хийгдсэн байх шаардлагатай. Хэрвээ өрөөнд өөр бусад хүмүүс байвал танд тэдний хэн болох яагаад энд байгааг хэлсэн байх үүрэгтэй. Та хэрвээ байлгахыг хүсэхгүй байвал тэднийг гарна уу гэж хэлэх эрхтэй;
- 7. Тав тух:** Та үзлэгийн үеэр аль болох тав тухтай байх ёстай. Таныг хэт удаан хүлээлгэхгүйгээр үзэх эсвэл хүлээх тухтай газартай байх шаардлагатай;
- 8. Дагалдах үзлэг:** Хэрвээ танд илүү нарийн үзлэг хэрэгтэй бол өмнө үзүүлж байсан хүн дээрээ очиж үзүүлэх боломжтой байх эсвэл өмнө нь таны авч байсан үйлчилгээг бичиж тэмдэглэсэн зүйлийг хүлээж авсан байх ёстай бөгөөд түүнийг шинэ эмч, сувилагч эсвэл эрүүл мэндийн ажилтан дээр авч очих хэрэгтэй.



Ажилчдын нөхөн олговор ба нийгмийн үйлчилгээ

Бараг ихэнх байгууллага өөрсдөөс нь шалтгаалсан гэмтэл бэртлийн тухайд үүрэг хариуцлага хүлээхийг хүсдэггүй ба хөдөлмөрийн чадвар алдсан ажилтныг дэмжихээс татгалздаг. Олон оронд ажилчдын нөхөн олговор, нөхөн сэргээх, бас хөдөлмөрийн чадвар алдалтын нөхөн олговрын хөтөлбөрүүдээр дамжуулан ажил дээрээ гэмтсэн ажилчдыг дэмждэг ч энэхүү мэдүүлгээр хүсэлт өгөх үйл явцыг ажил хэрэг болгоход хэцүү байдаг. Ажилчдын олон байгууллага ажилчдад тэдгээр мэдүүлгийг өгөхөд нь дэмжлэг үзүүлэхийг хүсдэг. Эдгээр хүсэлт нь мэдүүлэг гаргахаар ажиллаж байгаа хүмүүст маш их нэмэр болдог.

Үүний хажуугаар өөрийн гэмтэл, өвчлөл, бас нөхөн төлбөр болон бусад ажилчдад төлсөн нөхөн төлбөр, ялангуяа нэгээс илүү хүнд нөлөөлсөн үед юу болов гэх зэрэг мэдээллийг бүртгэж авах нь өөрийн гэсэн мэдээллийг бүрдүүлэхэд тус болно. Эдгээр мэдээллээ үйлдвэрчний эвлэл, эрүүл мэнд, аюулгүй байдлын хороо, дарга, бас бусад сонирхогч олон нийтийн байгууллагуудад тараан тэднийг бас мэдээлэлтэй болго. Ажлын аюул нь маш ноцтой байдаг ба үр дүнд нь ажилчид нөхөн төлбөр авдаг болохыг харуулах боломжтой болсноор нөхцөл байдлыг сайжруулах арга хэмжээнд хүмүүсийг зоригжуулан оролцуулахад тус болно.



Үйлдвэр нь мөн эдгээр аюулыг тодорхойлон, хүлээн зөвшөөрөх хүсэлгүй, нөхөн төлбөр төлөхөөс татгалзаж болох юм. Магадгүй хуульч, засгийн газрын ажилтан, байгаль орчны ажилтан, бас эмэгтэйчүүдийн байгууллага, сэтгүүлч, мөн тухайн үйлдвэрийн барааг худалдан авдаг илүү том байгууллагыг оролцуулах хэрэгтэй болж болох юм.

ГЭМТСЭН АЖИЛЧДЫГ ДЭМЖИХ БҮЛЭГ

Ийм бүлэг нь эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, эмчилгээ, нөхөн сэргээх, нийгмийн үйлчилгээнд хамруулах, бас ажилд нь буцаан оруулах талаар уулзалт хийж туршлага олгодог. Туршлагатай ажилчид нь дөнгөж гэмтээд байгаа ажилчдад тэтгэмж авахад нь, мөн нөхөн сэргэж буй эсвэл эдгэшгүйгээр гэмтсэн ажилтанд сэтгэл санааны дэмжлэг өгөхөд тусалж чадна. Ажил олгогч болон хамтран ажиллагчид зөвхөн гэмтлийг хархаас биш гэмтсэн хүнийг хардаггүй ба дэмжлэг үзүүлэх бүлэг нь таны өөрийн ур чадварт итгэх, өөртөө итгэлтэй байдлаа эргүүлэн олж авахад тань тусалж чадна.

ГЭМТСЭН АЖИЛЧДАД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ БА НИЙГМИЙН ДААТГАЛ

Эрүүл мэндийн тогтолцоо нь эмч нар ажилчдыг сонсож, ажлаас шалтгаалсан гэмтлийг тогтоох чиглэлээр бэлтгэгдсэн байх, мөн өвдсөн үед нь болон гэмтсэн ажилтныг илүү хурдан бас бүрэн гүйцэд нөхөн сэргээх чадавхтай байх хэрэгтэй. Үйлчилгээнд нь биеийн болон хөдөлмөрийн нөхөн сэргээлтийн, мөн хэрвээ тухайн ажлын тэдгээр аюул байхгүй болсон бол буцаж ажилд нь оруулах хөтөлбөр багтсан байх ёстой. Тухайн ажлаа дахин хийх чадваргүй болсон бол хөдөлмөрийн чадвар алдсан ажилтныг тохиромжтой ажилд сургах хөтөлбөрт хамруулах хэрэгтэй. Ажил олгогч болон засгийн газар нь хөдөлмөрийн чадвар бүрэн алдсан ажилтныг ажлын байр болон нийгэмд нь амьдрах газар, нөхөн олговрыг багтаасан нийгмийн даатгалын хөтөлбөрөөр хангах ёстой.

Улс бүрийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээ нь нэгдсэн эрүүл мэндийн үйлчилгээнээс хувийн эмнэлэг хүртэл өөр өөр хуулийн зохицуулалттай байдаг. Өөрийн орны эрүүл мэнд, нийгмийн даатгалын тухай хуулийг судалж, эмчид үзүүлэх чөлөө, эмчилгээний зардал эсвэл ажлаас үүдэлтэй эрүүл мэндийн асуудалд үзүүлэх эрүүл мэндийн онцгой хамгааллын аль нь ямар даатгалын тогтолцооноос санхүүждэг болохыг олж мэд.

Эрүүл мэндийн үйлчилгээ бол үйлдвэрчний эвлэлийн тэргүүлэх чиглэл юм

SITRACOR хувцас үйлдвэрлэгч ажилчдын үйлдвэрчний эвлэл нь Гондураст эрүүл мэндийн хүртээмжийг сайжруулах ажил хийж эхэлсэн юм. Тэд ажиллагчдын чөлөө авч эмчид үзүүлэх, бүх ажилчид улсын эрүүл мэндийн даатгалын системд бүртгэгдсэн байх эрхийн төлөө тэмцэж байв. Нэг эмэгтэй төрөхийн өмнөх үзлэгт явах зөвшөөрлийг нь өгөөгүйгээс ажил дээрээ үр зулбасны дараа тэд засгийн газар болон ТББ-аас маш их дэмжлэг авсан билээ.


SITRACOR нь мөн ажиллагчдын эрүүл мэндийн бусад нөхөн олговрыг өргөтгөхөөр ажиллаж байна. Жишээлбэл тэд хувцасны олон үйлдвэрийн ажилчид нүдний хувьд хэт ачаалалтай, гэмтэлтэй, бас цочирсон үедээ нүдээ үзүүлэх хэрэгтэй байсан ч нүдний шинжилгээ болон нүдний шилний төлбөрийг улсын эрүүл мэндийн даатгал төлдөггүй байв. SITRACOR нь үйлдвэрийн эздээр ажилчдын нүдний эмчилгээний зардлыг төлүүлэх кампанит ажил зохион байгуулсан юм. Тэд мөн үйлдвэрүүдээр ажилчдын уушгины өвчин, ДОХ, хорт хавдрын шинжилгээний зардлыг төлүүлэх тэмцэлд ялалт байгуулсан юм.

Ажилчдын эрүүл мэндийн ухуулагч

Үйлдвэрийн ажилчдын хэн нэг нь үйлдвэрийн эрүүл мэндийн ухуулагч болж болно. Хөдөлмөр хамгааллын зөвлөл нь тэдэнд ихэвчлэн ажлын байрны гэмтлээс урьдчилан сэргийлэхэд нь тусалдаг тул үүнийг бий болгох эсвэл түүнд нэгдэх нь сайн эхлэл болдог. Гэхдээ эрүүл мэндийн ухуулагч нар нь ажилчдад эрүүл мэндэд учирч болзошгүй аюулын талаар боловсрол олгохын зэрэгцээ хэрвээ эрүүл мэндийн асуудалтай болох үед эмчлүүлэх бол хүмүүст шийдэл олоход нь туслах зергээр илүү их зүйлийг хийж чаддаг. Эрүүл мэндийн ухуулагчид нь үйлдвэр дэх асуудлыг илүү сайн ойлгож, бас бусдад өвчтөн зовууриа эмчилж сурхад нь тусалж, дахин тохиолдохоос хэрхэн урьдчилан сэргийлэх талаар мэдэж авах, илүү эрүүл, сайн ажлын нөхцөлийн төлөө нэгдэх үйл ажиллагааг хөгжүүлдэг. Ажилчид өөрсдийн туршлагаа “гадны хүмүүс”-тэй хуваалцаж, зөвлөгөө өгөхөд илүү тааламжтай сэтгэгдэлтэй байдаг. Хэрхэн эрүүл мэндийн ухуулагч болох талаар 2 ба 3-р бүлгээс үзнэ үү.

Ажилчдын юунд итгэдгийг олж мэдсэнээр та эрүүл мэндийн хамгийн чухал асуудлын тухай сонирхол татаж, анхаарал хандуулахуйц сургалт болон материал боловсруулж чадна. Эрүүл мэндийн боловсролын тухай хичээл бэлдэж тайлбарлахдаа энэхүү номын мэдээллийг ашиглаарай:

- Үйлдвэрийн нөхцөл нь эрүүл мэндэд ямар байдлаар заналхийлж байгаа болох;
- Эрүүл мэндийн асуудлаас хэрхэн урьдчилан сэргийлэх;
- Ажлын аюулаас шалтгаалсан асуудлын шинж тэмдгийг хэрхэн тодорхойлох;
- Ажилчдын эрүүл мэндийн үйлчилгээ авах эрхийн төлөө яаж тэмцэх.



Нөхөрсөг эрүүл мэндийн ажилтан эсвэл олон нийтийн бүлэг нь магадгүй товхимол хийх, самбар ажиллуулах, бүлгийн хэлэлцүүлэг зохион байгуулах болон өөр өөр ажлын байрны асуудалд туслах боломжтой байж болно. Эдгээр яриа болон материал нь тухайн ажиллагчдын ярьдаг хэл дээр байх хэрэгтэй. Мөн тэдний амьдрал, ажилд тусахуйц байх ёстой.

Ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдлын талаарх сургалтууд

Азийн мониторингийн нөөцийн төв (AMRC) нь үйлдвэрийн хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хариуцдаг. Аюулыг газрын зурагт зааж оруулах зэрэг сургалтын тусламжтайгаар эдгээр байгууллагууд нь ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй байдлын туслахууд болдог ба заримдаа бүр улсын ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй байдлын үйл ажиллагааг явуулдаг. Хэдийгээр тэдэнд бүх сургалт эсвэл тоног төхөөрөмж, мэргэжилтэн байхгүй байж болох ч тэд ихэнх тохиолдолд орон нутгийн талаар хэнээс ч илүү сайн мэдлэгтэй, ажлын байранд ажиллах туршлагатай байдаг. Тэд ажилчдын амьдралд жинхнээсээ нөлөөлж чаддаг. Камбож, Индонези, бас Хятадад үйлдвэрийн аюулыг арилгах, ажилчдыг сургах, наад захын аюулгүй байдал болон хувийн хамгаалах хэрэгслээр хангах талаар ажил олгогчдыг ятгах үйл ажиллагаа явуулдаг.

Эрүүл мэндийн нийтлэг асуудлууд

Ажилчдын эрүүл мэндийн асуудлын дийлэнх нь тэдний амьдарч байгаа орчинд нийтлэг байдаг. Тэдгээр нь үйлдвэрийн ажлаас шалтгаалаагүй байж болох ч үйлдвэрийн нөхцөл нь тэдгээрийг илүү хүндрүүлэхэд нөлөөлдөг. Танай үйлдвэрт дараах нөхцөлүүд бий юу?

- Ажилчид яаж өвчин тусдаг, хэр ойр ойрхон өвдөж байна: Ажлын газрын аюулд агааржуулалтын муухан систем, химийн бодисоор амьсгалах, чанар муутай хүнс, эрүүл ахуйн шаардлага хангаагүй жорлон зэргийг багтаах ба эдгээр нь биеийг өвчлүүлж, халдварын эсрэг тэмцэх чадварыг сулруулдаг;
- Тэд хэрхэн өвчилж байна: Агаар дахь химийн бодис, тоос нь амьсгалын замын асуудлыг илүү хүндрүүлдэг. Чанар муутай хүнс, бохир жорлон нь нян тараадаг;
- Тэд хэр хурдан эрүүл болж байна: Амрах цаггүй эсвэл эмчид үзүүлэх завгүй байх нь тэднийг хурдан эдгэхэд саад болдог;
- Халдварт өвчин хэр хурдан бусдад тархаж байна: Цаг зав байхгүй эсвэл тогтмол гараа угаах цэвэр усгүй, бас агаарыг цэвэрлэхийн оронд бохир агаарыг ажлын байран дотор эргэлдүүлж байгаа нь үйлдвэр дотор нян тархаад нөлөөлдөг.

Ажилчид ихэнх цагаа ажил дээрээ өнгөрөөдөг тул үйлдвэр нь эрүүл мэндийн сурталчилгаа хийх хамгийн тохиромжтой байрлал юм. Үйлдвэрийн

дотор болон гадуур ажиллагчдын эрүүл мэндийг сайжруулахын тулд дарга нь ямар нэг зүйлээр дэмжихийг хүсэж байж болох юм. Эрүүл ажилчид нь ажлаа бага алдаж, ажил дээрээ илүү үр бүтээлтэй байдаг. Эрүүл ажилчид өөрсдөдөө болон гэр бүлдээ илүү сайн анхаарал хандуулах, бас олон нийтийн ажилд илүү идэвхтэй оролцох боломжтой болдог. Аливаа эрүүл мэндийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхдээ төлөвлөлтийн үе шатнаас нь эхэлж ажиллагчдыг оролцуул.

Ажлын байран дахь эрүүл мэнд, эрүүл ахуйн сургалт: Ажилчидтай ярилцаж эрүүл мэндийн ямар асуудал хамгийн нийтлэг байгааг мэдэж авах санал асуулга явуул. Ажил нь хүмүүсийн эрүүл мэндэд хэрхэн нөлөөлж байгаад анхаарлаа хандуулаагүй өнгөрсөн бол дарга нар эрүүл мэндийн сургалтад цаг гаргахаас өөр аргагүй болно. Ажлаас шалтгаалж байгаа асуудлыг өөрийн хэлэлцүүлэгтээ оруулах арга олох уран сэтгэмжтэй бай. Эмэгтэйчүүд эрүүл мэндийн асуудлаа илүү нээлттэй хэлэлцэж болохуйц зөвхөн эмэгтэйчүүдийн сургалтыг тусад нь хий.

Нөөц боломж: Наад захын нөөц боломж нь эрүүл мэндэд учирдаг нийтлэг асуудлаас урьдчилан сэргийлэхэд тусална. Эрүүл мэндийн зурагт хуудас зэрэгтээ хөрөнгө оруулагч, хандивлагч олж бас даргаасаа саван, ариутгасан салфетка, өвчин намдаагч, шингэн нөхөх уух зүйл болон бусад хэрэг болох нөөцөд хувь нэмрээ оруулна уу гэж хүс.

Хорт хавдар, ДОХ, БЗХӨ-ий үнэ төлбөргүй үзлэг: Эмнэлэг эсвэл ихэвчлэн орон нутгийн ашгийн бус эмнэлэг нь хорт хавдрыг эхэн үед илрүүлэх үзлэг, мөн умайн хүзүүний хорт хавдрыг шалгах цаасан дээрх түрхэц зэрэг үзлэгийг хийдэг. Ажилчид хувийн нууцлал, нууц хадгалах гэрээтэй, бас үнэгүй эмчилгээтэй байх нь тэдэнд БЗХӨ-ий үзлэгт ороход нь тус болдог.

Вакцинжуулах аян: Үйлдвэрт ажлын өмнө болон дараа эсвэл үдийн цайны цагаар эрүүл мэндийн хэлтсээ ажилчдыг вакцинаар үнэгүй хангах арга хэмжээ зохион байгуулахыг урь.

Эрүүл мэндийн нийтлэг асуудлыг шийдэх

Ихэнх өвчин зовуурийг амралт, тэжээллэг хүнс, бас их хэмжээний уух шингэн зүйлээр эмчилдэг. Мөн хэзээ эмчид үзүүлэх хэрэгтэй болохоо тодорхойлж сурч болно.

Түгээмэл ханиад нь вирусийн гаралтай байдаг ба бактерийн халдвартын эсрэг үйлчилгээтэй антибиотикоор эмчлэгдэггүй. Ахиухан шингэн, шөл, бас шүүс ууж амар. Зарим компани ханиадны эсрэг үнэтэй шахмал эм зардаг ч та яг адил үр дүнг илүү бага үнэтэй ацетаминофен эсвэл энгийн аспиринаас авч болдог. Ханиад нь нэг хүнээс нөгөөд маш амархан халдвартадаг. Гараа ойр ойрхон угааж, ханиаж, найтаах үедээ амаа таглаж, бас бусдадаа адилхан үйлдэл хий гэж хэл.

Шээсний замаар халдвартадаг (UTIs) өвчин ба давсагны халдварт нь эрэгтэйчүүдийг бодвол шээсний сүв нь богино, бас илүү их нян орж болдог учир эмэгтэйчүүдэд илүүтэй нөлөөлдөг. Эмэгтэйчүүд бэлгийн хавьталаад ороход, хангалттай ус уухгүй бол эсвэл хэт удаан шээхгүй бол шээсний замаар нян халдвартадаг. Их ус уу эсвэл танай соёлд түүнийг эмчилдэг гэх цайг уу. Чихэрлэг зүйл битгий уу. Ердөө шингэн зүйл ууснаар 2 өдрийн дотор таны бие сайжрахгүй бол танд магадгүй антибиотик (кортиномоксазол) уух хэрэгтэй байж болох юм. Эмчид үзүүл.

Суулгах нь маш олон зүйлээс шалтгаалдаг. Ихэнхдээ шингэнээс өөр эмчилгээ хэрэггүй байдаг. Хүн маш их шингэн алдах үедээ шингэнний дутагдалд орохгүйн тулд илүү их ус ууж, тэжээллэг хүнс хэрэглэх нь чухал юм. Хэрвээ гэдсэндээ юу ч байлгаж чадахгүй байвал дор хаяж 3 литр шингэн нөхөх уух зүйл хийж, маш удаанаар уу. 1 литр усыг хагас цайны халбага давс, 8 цайны халбага элсэн чихэртэй найруул. Давс нь таныг шингэнний дутагдалд оруулдаг тул та давсаа ихдүүлж болохгүй.

Конъюнктивит нь “нүд улайх” гэж нэрлэгддэг бөгөөд бактерийн гаралтай халдварт юм. Үүнийг антибиотик болон нүдний тосоор (триглицерин) тэр даруй эмчил.

Сүрьеэ (tuberculosis) нь хэрвээ та эмчилгээ хийлгэхгүй бол хамтран ажиллагчид, бас гэр бүлийнхэнд тань халдах болно. Сүрьеэгийн талаар илүү их мэдээллийг 31-р бүлгээс үзнэ үү.

ЭМЧ БАЙХГҮЙ ҮЕД, ЭМЭГТЭЙЧҮҮД ЭМЧ БАЙХГҮЙ ҮЕД зэрэг номыг уншиж, бас Хесперианы бусад номуудаас та эрүүл мэндийн асуудлын талаар, тэдгээрийг хэрхэн эмчлэх талаар мэдэж авах болно. Гэхдээ эм нь хэзээ ч эрүүл мэндийн сайн тусламж үйлчилгээг орлохгүй. Эрүүл мэндийн сайн тусламж үйлчилгээ нь яагаад эрүүл мэндийн асуудалтай



Эрүүл
мэндийн
мэдээлэл

(ургэлжлэл)

**Эрүүл
мэндийн
мэдээлэл**

болсон, илүү сайжрахын тулд юу хийж чадах, бас яаж ирээдүйд энэхүү асуудлаас урьдчилан сэргийлэхийг тайлбарлаж чадна.

Эмэгтэй ажилчид эрүүл мэндийн сурталчилгаа хийж зохион байгуулалтад оров

Манай байгууллага нь Хувиараа хөдөлмөр эрхлэгч эмэгтэйчүүдийн холбоо (SEWA) бөгөөд Энэтхэгт 1.3 сая эмэгтэй ажилчид үйлдвэрчний эвлэлд нэгдсэн байдаг. Бид эмэгтэй ажилчдын илүү сайн ажиллах нөхцөлийн төлөө тэмцдэг.

Эмэгтэй ажилчдын нүүр тулж байгаа хамгийн том асуудлын нэг нь эрүүл мэндийн үйлчилгээ авах боломж байдаггүй явдал юм. Тиймээс бид эмэгтэйчүүдтэй хамт эмчийн үзлэг ямар үнэтэй байсан, тэдэнд яагаад эмчид үзүүлэх хангалттай цаг байхгүй болох эсвэл мөнгөгүй байсан, бас ямар төрлийн эрүүл мэндийн үйлчилгээг тэд үнэхээр хүсэж байгаа талаар ярилцах уулзалтуудыг зохион байгуулсан юм. Бид эмэгтэйчүүдийг эрүүл мэндийн үйлчилгээ авахад нь хялбар болгохын тулд тэдгээрийг ойр болгох хэрэгтэй юм байна гэдэгт санал нэгдэв. Анхандаа бид жижиг, хөдөө орон нутгийн олон нийтийн анхдагч эрүүл мэндийн үйлчилгээний хөтөлбөр бий болгоход туслахаар шийдлээ.

Эхэндээ эмэгтэйчүүд олон үйл ажиллагаанаас зөвхөн гэр бүл төлөвлөлтийг сонирхдог байсан учраас биднийг бас л нэг гэр бүл төлөвлөлтийн ажил хийдэг гэж харсан. Бид илүү олон хүний итгэлийг олж, эмэгтэйчүүдийн нүүр тулж байгаа зарим асуудлыг мэдэж авч, удалгүй ямар асуудлууд тулгамдаад байгааг хамгийн сайн мэдэж байгаа хүмүүс нь эмэгтэйчүүд өөрсдөө гэдгийг ойлгож авсан юм. Тиймээс бид орон нутгийн эмэгтэйчүүдийн нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцэх олон нийтийн эрүүл мэндийн ажилтан болгох сургалтад хамруулж эхэлсэн билээ. Эрүүл мэндийн боловсрол, сургалт, шим тэжээлийн төв (CHETNA)-өөс дэмжлэг авч тэд эхний 10 эмэгтэйг сургаж эхлэхэд тусалсан юм.

Эхэндээ эмэгтэйчүүд урам нь хугарсан байдалтай байсан. Тэд хэлэхдээ, “Бид хэзээ ч сургуульд явж байгаагүй. Яаж та намайг олон нийтийн эрүүл мэндийн ажилтан болно гэж найдаж байна вэ? Хүмүүс бидний шоолж инээх болно” гэж байв. Гэвч тэд аль хэдийн зарим уламжлалт эмчилгээ, ёс заншил болон ямар асуудлууд байгааг мэддэг болохоо ойлгосон юм. Бид ямагт эмэгтэйчүүдийн аль хэдийн мэддэг зүйлсээс сургалтаа эхэлж, бас дараа нь бид тэдэнд болон олон нийтэд юу чухал болох, юу сурмаар байгааг нь асуудаг байв. Тэд одоо бусад эмэгтэйчүүдэд эрүүл мэндийн туслах болоход нь хамтран ажиллаж, хямд үнэтэй эмээр хангаж, сүрьеэгийн төв ажиллуулж, бас эрүүл мэндийн даатгал болон бусад үйлчилгээг санал болгож байна.

